



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 119

Номгон

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 5.1 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн цэцэрлэгийн барилга, аймгийн Нэгдсэн эмнэлгийн автомашин, Баянлиг сумын Эрүүл мэндийн төвийн автомашинуудыг хавсралтад заагдсан байгууллагуудад үнэ төлбөргүй балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хүрээмарал, Жаргалант, Бөмбөгөр, Баянцагаан сумдын Цагдаагийн кабон нь аймгийн Цагдаагийн газарт бүртгэлтэй тул Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын нэр дээр бүртгэлтэй 200м² талбай бүхий газар эзэмших эрх, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын нэр дээр бүртгэлтэй 627м² талбай бүхий газар эзэмших эрх, Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын нэр дээр бүртгэлтэй 480м² талбай бүхий газар эзэмших эрх, Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын нэр дээр бүртгэлтэй 700м² талбай бүхий газар эзэмших эрхийг тус тус аймгийн Цагдаагийн газарт шилжүүлэхийг Хүрээмарал, Жаргалант, Бөмбөгөр, Баянцагаан сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг комисс томилон, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж,

хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, хэрэгжилтийг 2018 оны 11 дүгээр сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд ирүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр сарын
13-ны өдрийн 119 дүгээр тогтоолын хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг /сум/- ын нэр	Байгуул агын нэр	Эд хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Ашиглах жил	Тоо	НБУ	Бүгд үнэ	Элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авсан байгууллагын нэр
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Шаргалжуут	Цэцэрлэг	Цэцэрлэгийн барилга	83.01.01	60	1	178666919	178 666 919	88 988 647,24	89 678 271,76	Баянхонгор сумын ЗДТГ-т
2	Баянхонгор аймаг	Нэгдсэн эмнэлэг	86-06БНА автомашин	09.01.27	6	1	14197000	14 197 000	14 197 000,00	-	Аймгийн Цагдаагийн газарт Гурванбулаг сумын Цагдаагийн ажилтанд
3	Баянлиг сум	ЭМТ	Түргэн тусламжийн УАЗ469 машин	13.10.10	6	1	19032142	19 032 142	15 860 118,47	3 172 023,53	Баянлиг сумын ИТХ- ын ажлын албанд
		ДҮН						211 896 061	119 045 766	92 850 295,29	

ооо